

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дүгээр сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ**

**/Шинэчилсэн найруулга/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага далайн боомтын үйлчилгээ эрхлэх, хөлөг онгоцоор далайд тээвэр хийх, далайн биологийн болон геологийн нөөц олборлох, далайд судалгаа, шинжилгээ хийх, хөлөг онгоц бүртгэх, далай дахь аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалах зэрэг далай ашиглах үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж**

2.1. Далай ашиглах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1. Энэ хууль Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага далайн боомтын үйлчилгээ эрхлэх, хөлөг онгоцоор далайд тээвэр хийх, далайн биологийн болон геологийн нөөц олборлох, далайд судалгаа, шинжилгээ хийх, хөлөг онгоц бүртгэх, далай дахь **хүний** аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалах зэрэг далай ашиглах үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад улсын харьяалал, өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран үйлчилнэ.

## 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурьдсан утгаар ойлгоно:

4.1.1. “далай ашиглах үйл ажиллагаа” гэж хөлөг онгоцоор дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхийг хэлнэ. Үүнд:

- а) ачаа бараа, зорчигч, тэдгээрийн тээш тээвэрлэх,
- б) далайн биологийн нөөц олборлох, хайгуул хийх,
- в) далайн геологийн нөөц олборлох, хайгуул хийх,
- г) далайн чиглүүлэгчийн үйлчилгээ үзүүлэх болон мөс цөмөлж зам гаргах,
- д) аваар ослын үеийн эрэн хайлт, аврах болон чирэх үйл ажиллагаа,
- е) далайд живсэн эд хөрөнгийг гаргах,
- ё) гидравлик ажил, усан доорх инженерчлэл болон бусад ижил төстэй ажил,
- ж) далайн орчныг хамгаалах,
- з) далайн шинжлэх ухааны судалгаа явуулах,
- и) **аялал жуулчлал**, соёл, спорт, сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх,
- к) хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаа явуулах,
- л) далайн боомт ашиглах,
- м) ариун цэвэр, мал эмнэлэг, ургамлын болон бусад хорио цээрийн хяналт зэрэг үйл ажиллагаа.

4.1.2. “далайн тээвэр” гэж далай ашиглах үйл ажиллагаатай холбогдсон бүх төрлийн тээврийг хөлөг онгоцоор гүйцэтгэхийг;

4.1.3. “хөлөг онгоц” гэж хөдөлгүүртэй буюу хөдөлгүүргүй далай ашиглах үйл ажиллагаа явуулахад зориулагдсан инженерийн, тээврийн хөвөгч байгууламжийг;

4.1.4. “бербоут-чартер” гэж түрээслэгч хөлөг онгоцыг өөрийн эзэмшил, ашиглалтад авч түүнд бүрэн хяналт тавьж, хөлөг онгоцны ахмад болон багийн бүрэлдэхүүнийг сонгож томилох эрхтэйгээр хөлөг онгоцыг түрээслэгчид шилжүүлж байгаа албан ёсны гэрээг;

4.1.5. “коносамент” гэж тээвэрлүүлэгчээс тээвэрлэгчид олгодог ачаа барааг хүлээн зөвшөөрөх тээвэрлэлтийн баримт бичгийг;

4.1.6. “далайн чиглүүлэгч” гэж тухайн боомтын усан мандлаар хөлөг онгоцыг аюулгүй залуурдаж чиглүүлэгч үүрэг бүхий этгээдийг;

4.1.7. “далайн боомт” гэж далайн тээвэр эрхэлж байгаа хөлөг онгоцуудад үйлчилгээ үзүүлэх зорилгоор тусгайлан барьсан далайн эргийн цогцолбор байгууламжийг;

4.1.8. “тээвэрлүүлэгч” гэж далайн тээвэрлэлтийн гэрээ, тээврийн баримт бичигт заасны дагуу ачаа бараа илгээх эрх авсан иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг;

4.1.9. “зорчигч” гэж зорчих тасалбар болон бусад баримт бичгээр зорчих эрхээ баталгаажуулсан этгээдийг;

4.1.10. “тээвэрлэгч” гэж хөлөг онгоцоор ачаа бараа болон зорчигч тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийг;

4.1.11. “тээвэрлэлтийн гэрээ” гэж тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нарын хооронд ачаа бараа тээвэрлэхээр байгуулсан албан ёсны гэрээг;

4.1.12. “бүртгэгч” гэж хөлөг онгоцыг бүртгэх чиг үүрэг бүхий далайн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон төрийн **жинхэнэ** албан хаагчийг;

4.1.13. “бүртгэлийн боомт” гэж Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцны харъяалагдаж буй боомтыг;

4.1.14. "Олон Улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллага" гэж бүх төрлийн хөлөг онгоцыг угсарч бүтээх, түүнд хэрэглэх материал, хөлөг онгоцны тоног төхөөрөмж, түүнчлэн галын аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, бусад хэрэгслээр тоноглох журмыг боловсруулан гаргаж, хөлөг онгоцны зураг төсөл зохиох, барих, ашиглах явцад тэдгээрийн мөрдөлтөд хяналт тавих үүрэг бүхий олон улсын байгууллагыг;

4.1.15. "аяллын шаардлага" гэж тухайн төрөл, зориулалтын хөлөг онгоц экологи, аюулгүйн болон техник **ашиглалтын** дүрмийн шаардлага хангасан, аюулгүй аялахад **стандартын шаардлага хангагдсан байдлыг**;

4.1.16. “ахмад” гэж худалдааны далайн тээврийн үйл ажиллагааг аюулгүй хэрэгжүүлэхийн тулд хөлөг онгоц, багийн бүрэлдэхүүнийг хөлөг онгоцны өмчлөгч, эзэмшигчдийн өмнө хариуцан удирдаж буй этгээдийг;

4.1.17. “хөлөг онгоцны баг” гэж хөлөг онгоцны аюулгүй ажиллагааг хангах үүрэг бүхий мэргэжлийн бүрэлдэхүүнийг;

4.1.18. “ачаа” гэж хөлөг онгоцоор тээвэрлэж буй шуудан, хөлөг онгоцны нөөц хангалт, хөлөг онгоцны сэлбэг материал, тоног төхөөрөмж, хөлгийн багийн гишүүдийн эд хогшил болон зорчигчдын дагалдах ачаанаас бусад бүх төрлийн үйлдвэрлэлийн болон худалдааны бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Далай ашиглах талаархи төрийн болон төрийн бус байгууллагын бүрэн эрх**

#### **5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**

5.1. Монгол Улсын Их Хурал далай ашиглах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Далай ашиглах талаар төрөөс баримтлах бодлого тодорхойлох;

5.1.2. Олон улсын далайн тээврийн холбогдолтой гэрээ, хэлэлцээр соёрхон батлах;

5.1.3. Далай ашиглах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

5.1.4. **Далайн тээврийн талаархи олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох гарах асуудлыг шийдвэрлэх.**

#### **6 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**

6.1. Монгол Улсын Засгийн газар далай ашиглах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Далай ашиглах талаар төрөөс баримтлах бодлого хэрэгжүүлэх;

6.1.2. Далай ашиглах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх;

6.1.3. Далайд геологийн болон биологийн нөөц олборлох, хайгуул хийх, боомт ашиглах, далайн шинжлэх ухааны судалгаа явуулах, соёл, спорт, сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах талаар бодлого хэрэгжүүлэх, хянан шалгах.

6.1.4. Далайн геологийн болон биологийн нөөц олборлох, хайгуул хийх асуудлыг тухайн салбарын асуудал хариуцсан Олон Улсын

байгууллага болон гадаад улс орнуудын Засгийн газартай гэрээ, хэлэлцээр хийх замаар шийдвэрлэх.

6.1.5. Ариун цэвэр, хорио цээр, мал эмнэлэг, ургамлын болон бусад хорио цээрийн хяналт хэрэгжүүлэх.

6.1.6. Гадаад орны эрх бүхий байгууллагаас олгосон далайчны үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх;

## **7 дугаар зүйл. Далайн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

7.1. Далайн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Далайн тээврийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

7.1.2. Далай ашиглах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

7.1.3. Хөлөг онгоцоор тээвэр хийх асуудлыг Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн зохицуулж, хяналт тавих;

7.1.4. Далайн тээвэрлэлтийн үйл ажиллагаа, хөлөг онгоц, далайн боомтын байгууламжийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;

7.1.5. Далайн тээврийн асуудлаар олон улсын үйл ажиллагаанд оролцох, улс хооронд тээвэрлэх ачаа, зорчигчдын хэмжээ болон тээвэрлэлтийн аюулгүй байдал, үйлчилгээний чанарын шаардлагын талаар холбогдох улстай тохиролцох;

7.1.6. Далайн тээвэрлэлттэй холбогдох баримт бичиг бүрдүүлэлт, хөтлөлтийн журмыг баталж, мөрдүүлэх.

7.1.7. Хөлөг онгоцоор аюултай ачаа тээвэрлэх журмыг баталж, мөрдүүлэх,

7.1.8. Далайн боомт ашиглах, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх,

7.1.9. Далай ашиглах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтийг зохицуулах,

7.1.10. хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд ажиллах үндэсний боловсон хүчний ойрын болон хэтийн хэрэгцээг тодорхойлох, түүнийг олон улсын зохих гэрээнд нийцүүлэн бэлтгэх ажлыг зохион байгуулах.

7.1.11. далайн чиглэлээр дотоод, гадаадын холбогдох байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах, мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх;

7.1.12. Далайн тээврийн хөлөг онгоц бүртгэх журмыг баталж мөрдүүлэх;

7.1.13. Далайн тээврийн хөлөг онгоцны техникийн болон үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргах.

7.2. Далайн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь далайн геологийн болон биологийн нөөц олборлох, хайгуул хийх асуудлыг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.

7.3. Далайн тээврийн хөлөг онгоц бүртгэх, Монгол Улсын төрийн далбаа мандуулах эрх, хөлөг онгоцны улсын бүртгэлийн гэрчилгээ болон өмчлөлийн талаар нотлох баримт, аялах эрх, радио холбооны лиценз, хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүний тоог тогтоосон гэрчилгээг түүнтэй холбогдсон гэрчилгээ олгох асуудлыг хэрэгжүүлнэ.

7.4. Далай ашиглах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, Олон Улсын Далайн Байгууллагатай харилцан хамтран ажиллаж, энэ чиглэлээр ажиллах төрийн байгууллагуудын уялдаа холбоог зохицуулах чиг үүрэг бүхий нэгж Далайн захиргаа, **судалгаа шинжилгээний байгууллагыг** далайн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өөрийн бүтцэд ажиллуулна.

## 8 дүгээр зүйл. Далай ашиглах үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг

8.1. Байгууллага, аж ахуйн нэгж нь далай ашиглах үйл ажиллагааг энэхүү хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенци, **түүний протоколоор** тогтоосон хэм хэмжээ, хязгаарын хүрээнд явуулна.

8.2. Далай ашиглах үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж нь дараах үүрэг хүлээнэ:

8.2.1. хөлөг онгоцны техникийн бүрэн бүтэн байдлыг мэргэжлийн байгууллагаар хянуулах, **дүгнэлт гаргуулах;**

8.2.2. хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авах;

8.2.3. хөлөг онгоцыг зориулалтаар нь ашиглах;

8.2.4. багийн бүрэлдэхүүнийг олон улсын зохих конвенцид нийцүүлэн бүрдүүлэх, ахмадыг томилох, чөлөөлөх;

8.2.5. ахмадын зөвшөөрлөөр хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, өөрчлөх;

8.2.6. хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах зорилгоор олон улсын далайн тээврийн, хөлөг онгоцны болон далайн боомтын мэргэжлийн байгууллагуудтай тохиролцон шаардлагатай үед холбогдох мэргэжилтэн, далайн чиглүүлэгчийг гэрээгээр авч ажиллуулах.

8.2.7. хөлөг онгоцон дээр ажиллагсад, зорчигчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;

8.2.8. хөлөг онгоцноос далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, бохирдсон үед холбогдох арга хэмжээ авах;

8.3. Далай ашиглах үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж нь далайн боомтын мэргэжлийн байгууллагаар дараах хяналтын үйл ажиллагааг гүйцэтгүүлнэ:

8.3.1. багийн бүрэлдэхүүний тоо тухайн төрөл, зориулалтын хөлөг онгоцонд тогтоосон доод хэмжээнээс цөөнгүй бөгөөд тэдний ахуй амьдрал, аюулгүй байдлыг хангасан бүх төрлийн нөөц байгаа эсэх;

8.3.2. хөлөг онгоцны баримт бичиг, багийн бүрэлдэхүүний диплом, мэргэжлийн гэрчилгээ, далайчны үнэмлэхийг олон улсын зохих конвенцийн шаардлагын дагуу бүрдүүлсэн эсэх;

8.3.3. хөлөг онгоцны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал олон улсын зохих конвенцийн шаардлагад нийцсэн эсэх;

8.3.4. хөлөг онгоцны холбооны тоног төхөөрөмж олон улсын зохих конвенцийн шаардлагад нийцсэн эсэх.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **Далайн тээвэр**

#### **9 дугаар зүйл. Далайн тээвэр болон тээвэрлэлтийн гэрээ**

9.1. Тээвэрлэгч далайн тээвэрлэлт хийхдээ ачаа эзэмшигчтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулан гүйцэтгэнэ.

9.2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу тээвэрлэхийг хориглосон ачаа барааг хөлөг онгоцоор тээвэрлэх болон тээвэрлүүлэхийг хориглоно.

9.3. Тээвэрлэлтийн гэрээг бичгээр байгуулах ба коносамент, чартер, далайн тээврийн хуудсаар баталгаажна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** **Хөлөг онгоцны бүртгэл**

### **10 дугаар зүйл. Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаа**

10.1. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэгч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. Хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх, тухайн хөлөг онгоцон дээр Монгол Улсын төрийн далбааг мандуулан аялах эрхийн гэрчилгээ олгох, бүртгэлээс хасах;

10.1.2. Олон улсын зохих конвенцид нийцүүлэн хөлөг онгоцтой холбоо барих олон улсын харилцаа холбоо ашиглах асуудлыг зохицуулах;

10.1.3. Монгол Улсын төрийн далбаа мандуулан аялах эрхийг авсан хөлөг онгоцны мэдээллийг бүртгэлийн мэдээлэлийн санд оруулах;

10.1.4. Төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа буюу бербоут болон бусад чартераар түрээсэлж байгаа хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.

10.1.5. Олон Улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллагаар техникийн үзлэг хяналт хийлгэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.

10.2. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэл нээлттэй байна.

10.3. Хөлөг онгоцыг хөлөг онгоц эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан, ашиглалтаас хассан, өөр улсад шилжүүлсэн, сүүлчийн удаа холбоо тогтоосон өдрөөс хойш гурван сар, дайн, зэвсэгт мөргөлдөөн болж буй бүсэд зургаан сараас дээш хугацаагаар сураггүй алга болсон тохиолдолд Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлээс хасна.

10.4. Гадаад улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцыг бербоут-чартераар түрээсэлсэн, уг хөлөг онгоц нь зохих мэргэжил боловсрол эзэмшсэн, дадлага туршлагатай багаар хангагдсан бол түүнийг нэг удаагийн



аяллын гэрээг үргэлжлүүлэх хугацаанд дангаар түрээсэлсэн хөлөг онгоц гэж үзэж Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.

10.5. Монгол Улсын Төрийн далбаа мандуулах эрхийг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц эдэлнэ.

10.6. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц нийслэл Улаанбаатар хотын харъяалалтай байна.

10.7. Тухайн хөлөг онгоц Монгол Улсад харьяалагдаж буйг тодорхойлох бэлгэ тэмдэг нь Монгол Улсын Төрийн далбаа байна.

10.8. Хөлөг онгоцон дээр Төрийн бэлгэ тэмдгийн тухай 2 хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Төрийн далбааг мандуулах ба дүрсэлнэ.

10.9. Бүртгэлийн боомтын дарга нь тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

10.10. Бүртгэлийн боомтын дарга нь бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулах.

10.11. Бүртгэлийн боомтын дарга нь хөлөг онгоцны бүртгэлтэй холбоотой бүх төрлийн гэрчилгээний үнэ тариф, бусад хураамжийн хэмжээг тогтооно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **Хөлөг онгоц болон түүний баг, хөлөг онгоцны аюулгүйн үйл ажиллагаа, далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх**

#### **11 дүгээр зүйл. Хөлөг онгоц**

11.1. Хөлөг онгоц нь Монгол Улсын хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд нийцүүлэн шаардлагатай бүх баримт бичгийг бүрдүүлсэн байна.

11.2. Хөлөг онгоц нь багийн бүрэлдэхүүн болон зорчигчийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах, тээвэрлэх ачааны бүрэн бүтэн байдлыг хадгалах, далайн орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх нөхцлийг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

#### **12 дугаар зүйл. Хөлөг онгоцны баг**

12.1. Хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд хөлөг онгоцны ахмад, хөлөг онгоцны удирдах багийн гишүүд болон бусад ажилтан орно.

12.2. Хөлөг онгоцны удирдах ажилтанд хөлөг онгоцны ахмадаас гадна, туслах ахмад, хөдөлгүүрийн инженерүүд, цахилгааны инженерүүд, радио холбооны мэргэжилтнүүд болон эмч нар хамаарагдана.

12.3. Хөлөг онгоцны удирдах ажилтнуудаас бусад нь багийн гишүүдэд хамаарагдана.

12.4. Хөлөг онгоцны багийн гишүүн дараах үүрэгтэй:

12.4.1. хөлөг онгоц, түүн дээр байгаа этгээдийн аюулгүй байдалд хор хохирол учруулахгүйгээр үүргээ хэрэгжүүлэх;

12.4.2. өөрийн мэдсэн буюу олж илрүүлсэн аялалын аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүй аливаа аюулыг ахмадад мэдээлэх;

12.4.3. үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх чадварт нь нөлөөлөх нөхцөл байдал үүсгэсэн аливаа өөрчлөлтийн талаар ахмадад мэдээлэх;

12.4.4. ахмадын хууль ёсны тушаал, шаардлагыг биелүүлэх.

### **13 дугаар зүйл. Хөлөг онгоцны ахмад, түүний үүрэг, эрх**

13.1. Хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнийг ахмад удирдана.

13.2. Ахмад нь багийн бүрэлдэхүүн болон зорчигчийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийг хамгаалах, хөлөг онгоцон дээрх ачааны аюулгүй ба бүрэн бүтэн байдлыг хадгалах үүрэгтэй.

13.3. Хөлөг онгоц далайд аялах, боомтод зогсох үед байгалийн болон техникийн аюул ослын улмаас үүссэн нөхцөл байдал нь хөлөг онгоц эзэмшигч эд хөрөнгийн нэхэмжлэл гаргах үндэслэл болохоор байвал ахмад нь хөлөг онгоц эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор уг боомтын тогтоосон журмын дагуу өөрийн улсын консулд буюу тухайн улсын эрх бүхий албан тушаалтанд далайн мэдэгдэл гаргаж болно.

13.3.1. Далайн мэдэгдэлд аюул ослын нөхцөл байдал, итгэмжлэгдсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах талаар ахмадын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан байвал зохино.

13.4. Ахмад нь багийн бүрэлдэхүүнийг урамшуулах, сахилгын дүрмийн дагуу арга хэмжээ авах эрхтэй.

### **14 дүгээр зүйл. Хөлөг онгоцонд аюул учрах**

14.1. Ахмад нь багийн бүрэлдэхүүн болон зорчигчийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хөлөг онгоц ба түүн дээрх ачаанд учирч болзошгүй аюул ослоос

урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгахад шаардлагатай арга хэмжээ авна.

14.2. Байгалийн онцгой аюул, давагдашгүй хүчин зүйлийн улмаас хөлөг онгоц, түүн дээрх ачаа, эд хөрөнгөд учирсан хохирлыг Монгол Улсын олон улсын гэрээнд заасан журмын дагуу зохицуулна.

## **15 дугаар зүйл. Далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх**

15.1. Монгол Улсын далбаан дор хөлөг онгоцоор далайн тээврийн үйл ажиллагаа явуулж буй этгээд олон улсын гэрээнд нийцүүлэн далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

## **16 дугаар зүйл. Тусламж үзүүлэх**

16.1. Хөлөг онгоцны ахмад тусламж хүссэн тухай мэдээг хүлээн авмагц өөрийн хөлөг онгоц болон түүн дээр байгаа этгээдэд ноцтой аюул учруулахгүйгээр далайд үхэх аюул тулгараад буй этгээдэд өөрийн боломж бололцоогоороо тусламж үзүүлэх үүрэгтэй.

16.2. Хөлөг онгоц мөргөлдсөн тохиолдолд хөлөг онгоцны ахмадууд харилцан туслалцах аргыг хамтран тодорхойлж, бололцоотой бүх арга, хэрэгслээр бие биедээ тусламж үзүүлэх үүрэгтэй.

16.3. Хөлөг онгоц мөргөлдсөний улмаас болон түүнийг аврах ажиллагааны үед учирсан эд хөрөнгийн хохирлыг Монгол Улсын олон улсын гэрээнд заасан журмын дагуу зохицуулна.

## **17 дүгээр зүйл. Хөлөг онгоцыг орхих**

17.1. Хөлөг онгоц сүйрэх нь гарцаагүй болсон тохиолдолд ахмад нь зорчигч, багийн бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч, хөлөг онгоцыг орхих шийдвэр гаргана.

17.2. Ахмад нь зорчигч, багийн бүрэлдэхүүн хөлөг онгоцыг орхисны дараа хөлөг онгоцны баримт бичгийг авч, хамгийн сүүлд хөлөг онгоцыг орхино.

## **18 дугаар зүйл. Хөлөг онгоцон дээр гэмт хэрэг гарах**

18.1. Хөлөг онгоцон дээр гэмт хэрэг гарсан тохиолдолд ахмад нь хэрэг бүртгэх ажиллагааг гүйцэтгэнэ.

## **19 дүгээр зүйл. Хөлөг онгоцон дээр хүн төрөх, нас барах**

19.1. Хөлөг онгоцон дээр хүүхэд төрсөн буюу хүн нас барсан тохиолдолд ахмад нь хоёр гэрч болон хөлөг онгоцны эмчийг байлцуулан баримт үйлдэж, энэ тухай хөлөг онгоцны дэвтэрт тэмдэглэл хийнэ.

19.2. Ахмад нь нас барсан хүний эд хөрөнгийн жагсаалтыг хоёр гэрчийг байлцуулан үйлдэж, эд хөрөнгийг эрх бүхий байгууллага, этгээдэд хүлээлгэн өгөх хүртэл хадгална.

19.3. Ахмад нь хөлөг онгоц боомтод хүрэлцэн ирсэн даруйд тухайн улсад суугаа уг нас барагчийн харьяалагдах улсын консулд шарилыг эд хөрөнгийн хамт хүлээлгэн өгнө.

19.4. Хөлөг онгоц далайд удаан хугацаагаар аялах болон шарилыг хадгалах боломжгүй байгаа онцгой тохиолдолд ахмад нь зохих баримт бүрдүүлэн шарилыг далайчдын ёс заншлын дагуу далайд оршуулж болно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

### **Бусад зүйл**

## **20 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

20.1. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

---oO---

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**